



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2018 оны 9 сарын 25 өдөр

Дугаар 402

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө нээлттэй дуудлагын
худалдаагаар худалдах зөвшөөрөл
олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 9, 29 дүгээр зүйл, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2016 оны 128 дугаар тогтоолын 5.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Геологийн судалгааны төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн нийт 34,085,465.80 (гучин дөрвөн сая наян таван мянга дөрвөн зуун жаран таван төгрөг наян мөнгө) төгрөгийн балансын үнэ бүхий 4 ширхэг суудлын автомашиныг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтад заасны дагуу тогтоосугай.

2. “Геологийн судалгааны төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын захирал Н.Ганболдод дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан автомашиныг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Дуудлагын худалдаанаас олох орлогыг зохих захиргааны актын дагуу байгууллагын дансанд төвлөрүүлэх;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.4. Энэ тогтоолын биелэлтийг 2019 оны 1 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Ц.НЯМ-ОСОР

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ГАВАА



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2018 оны 9 дугаар сарын 25-ны өдрийн
404 дугаар тогтоолын хавсралт

**"ГЕОЛОГИЙН СУДАЛГААНЫ ТӨВ" ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД
БҮРТГЭЛТЭЙ, НЭЭЛТТЭЙ ДУУДЛАГЫН ХУДАЛДААГААР ХУДАЛДАХ
ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ЖАГСААЛТ**

Д/д	Суудлын автомашины марк, улсын дугаар, арлын дугаар	Үйлдвэр-лэсэн/Ашиглалтад орсон он	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)	Худалдах доод үнэ (төгрөг)
1	Суудлын автомашин, УАЗ-31512, УББ 40-01, арлын дугаар 31510020130948	2002/2002	3,807,623.90	3,807,623.90	-	500,000.00
2	Суудлын автомашин, УАЗ- 31512, УБЛ 73-62, арлын дугаар 40595264	2004/2008	4,075,000.00	4,075,000.00	-	500,000.00
3	Суудлын автомашин, УАЗ-31512, УБЯ 04-18, арлын дугаар 0661252	1998/2004	13,366,000.00	13,366,000.00	-	500,000.00
4	Суудлын автомашин, УАЗ-2206, УБГ 19-03, арлын дугаар 50472378	2005/2006	12,836,841.90	12,836,841.90	-	500,000.00
	Нийт дүн		34,085,465.80	34,085,465.80	-	2,000,000.00
			(гучин дөрвөн сая наян таван мянга зуун жаран таван төгрөг наян мөнгө)	(гучин дөрвөн сая наян таван мянга дөрвөн зуун жаран таван төгрөг наян мөнгө)		(хоёр сая)